

МОНГОЛ УЛСЫН ЕВРОГООР ХИЙСЭН ГАДААД ХУДАЛДАА БОЛОН ТҮҮНИЙ ИНФЛЯЦИД НӨЛӨӨЛӨХ ЭСЭХ

Судалгааны хэлтсийн эдийн засагч А. Хулан

Оришил


Сүүлийн 3 жилд доллартай харьцах еврогийн ханш огцом чангарч байна. Жишээлбэл, 2001 оны дунджаар¹ 1 еврогийн 1 ам. доллартай харьцах ханш 0.90 доллар байсан бол, 2003 оны дунджаар 1.13 доллар болж 26.3%-иар өссөн байна. 2004 оны 3-р улирлын дунджаар 1 евро 1.222 доллартай тэнцэх болж 2003 оны мөн үеэс 8.6%-иар өссөн байна. (Зураг 1.)

Зураг 1. Доллартай харьцах еврогийн ханш



Манай орны хувьд төгрөгтэй харьцах еврогийн ханшийг өөрсдийн зах зээл дээр тогтоодоггүй, харин дэлхийн зах зээл дээр тогтсон евротой харьцах ам. долларын ханшаар дамжуулан тогтоодог.

Зураг 2. Төгрөгтэй харьцах евро, долларын ханш (төгрөгөөр)



¹ Европын Төв Банкны ханшийн мэдээлэлд үндэслэв. Вэб сайт:
<http://www.ecb.int/stats/exchange/eurofxref/html/index.en.html#data>

Иймд төгрөгтэй харьцах еврогийн ханшийн хөдөлгөөн доллартай харьцах еврогийн ханшийн хэлбэлзлээс нэг их зөрдөггүй. Еврогийн ханш чангарч байгаагаас евротой харьцах төгрөгийн ханш сүүлийн 3 жилд нилээн суларчээ. (Зураг 2.)

Хүснэгт 1. Евро болон долларын төгрөгтэй харьцах ханш болон түүний өсөлт (жилийн дунджаар)


	Доллар	Өөрчлөлтийн хувь	Евро	Өөрчлөлтийн хувь
1999	1020.71		1089.47	
2000	1075.33	5.35 %	995.65	-8.61 %
2001	1097.63	2.07 %	983.33	-1.24 %
2002	1111.63	1.28 %	1058.85	7.68 %
2003	1148.43	3.31 %	1303.81	23.13 %
2004 ²	1179.73	2.73 %	1447.96	11.06 %

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн жилүүдэд ам. долларын ханшийн өсөлт харьцангуй тогтвортой байхад, еврогийн ханшийн өсөлт -8.61 %-иас 23.13 %-ийн хооронд хэлбэлзсэн байна. 2000 онд еврогийн ханш 1999 оны дунджаас 8.61 %-иар буурсан бол 2003 онд ханшийн өсөлт дунджаар 23.13 % байв. 2004 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар еврогийн ханш 1541.60 төг. байгаа нь 2003 оны мөн өдрийн ханш болох 1373.90 төгрөгөөс 12.2%-иар өсчээ.

Энэхүү судалгаагаар еврогийн ханшийн дээр дурьдсан чангаралт нь еврогоор төлбөр хийгдсэн импортоор дамжин манай орны инфляци буюу үнийн өсөлтөд нөлөөлж буй эсэхийг тогтоохыг зорилоо.

2004 оны 9 сарын дүнгээр оны эхнээс тооцсон инфляци 8.9 % байна. Харин 2003 оны мөн үетэй харьцуулахад 12.6 % байв. 2003, 2002, 2001, 2000 онуудад инфляци тус бүр 4.7 %, 1.6 %, 8.0 %, 8.1 % байжээ. (Зураг 3.)

Зураг 3. Инфляци



² 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийг хамруулах дунджаар тооцов.

Судалгааны дүн

Еврогийн төлбөртэй гадаад худалдааны мэдээллээс үзэхэд сүүлийн жилүүдэд еврогоор төлбөр хийгдсэн бараа бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өсч ирсэн боловч нийт импортын дийлэнхийн төлбөр нь ам. доллароор хийгддэг байна. (Хүснэгт 2.) Үүний дотор техник тоног төхөөрөмжийн импортын дүнд еврогийн төлбөртэй импортын эзлэх жин бусад төрлийн бараа бүтээгдэхүүний дүнгээс их байна.

Хүснэгт 2. Импортын бүлгүүдийн мөнгөн дүнд еврогоор төлбөр хийгдсэн бараа бүтээгдэхүүний эзлэх жин (%)³

	2000	2001	2002	2003	2004 ⁴
Хүнсний бүтээгдэхүүн	0.33 %	0.25 %	5.78 %	8.36 %	5.91 %
Хэрэглээний бүтээгдэхүүн	0.11 %	0.33 %	3.09 %	6.03 %	7.55 %
Эрдэс бүтээгдэхүүн	0.00 %	0.00 %	0.02 %	0.06 %	0.04 %
Түүхий эд болон эд анги	0.46 %	0.66 %	5.37 %	8.86 %	5.23 %
Техник тоног төхөөрөмж	0.98 %	1.16 %	4.30 %	12.66 %	10.36 %
Нийт импорт	0.47 %	0.54 %	3.64 %	7.69 %	6.40 %

Хэдийгээр ийнхүү еврогоор төлбөр хийгдсэн импорт өсч байгаа боловч мөнгөн дүнгээр нийт импортын 10 хүрэхгүй хувийг эзэлж байна. Инфляцийн түвшинг тодорхойлогч хэрэглээний үнийн индексийн гол бүрэлдэхүүн болох хүнсний болон хэрэглээний барааны импортод еврогийн төлбөрт импортын эзлэх жин 8 хувиас хэтрэхгүй байна. Иймээс еврогоор төлбөр хийгдсэн бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийг ХҮИ-т нөлөөлнө гэж хэлэхэд бэрх.

Дүгнэлт

Шилжилтийн эдийн засагтай манай орны хувьд инфляци нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс гадна нийгмийн олон хүчин зүйлээс шалтгаалан хэлбэлзэл өндөртэй байна. Үүнээс гадна нийт хүнсний болон хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортод еврогийн төлбөрт бараа бүтээгдэхүүний эзлэх жин 8 хувиас хэтрэхгүй байна. Ийм ч учираас одоогийн байдлаар монгол улсын нийт импортын 10 хүрэхгүй хувийг эзлэх еврогоор төлбөр хийгдсэн бараа бүтээгдэхүүний үнэ нь зах зээлийн үнэд нөлөөлөх замаар инфляцид нөлөөлж байна гэж хэлэх боломжгүй. 2000 оноос 2004 оны импортын мэдээнд үндэслэн хийсэн корреляцийн шинжилгээ ч энэ дүнг баталлаа.

2004 оны 5 дугаар сарын 1-ний өдөр манай худалдааны түнш олон орнууд хүчээ авч буй Европын Холбоонд элссэн бөгөөд, ирээдүйд ч зарим европын орнууд шинээр элсэхтэй холбоотойгоор Монгол улсын еврогийн төлбөрт гадаад худалдаа ихсэх нь дамжиггүй. Иймтээс эдгээр орнуудтай хийх худалдаа өргөжин тэлэхийн хэрээр еврогийн ханшийн өөрчлөлт манай орны инфляцид нөлөөлөхийг үгүйсгэх аргагүй юм.

³ Дэлгэрэнгүй тоо баримтыг хавсралтаас үзнэ үү.

⁴ 2004 оны 9 дүгээр сар хүртэлх импортын дүнгээр тооцов.

Хавсралт 1. Монгол улсын еврогоор төлбөр хийсэн импорт, түүний нийт импортод эзлэх жин. 2000 он

		Евро төлбөрт импорт (ам. доллар)	Нийт импорт (ам. доллар)	Евро төлбөрт импорт/ нийт импорт (%)
Хүнсний бүтээгдэхүүн	1. Амьд мал, амьтад, мал малын гаралтай бүтээгдэхүүн	0.0	2,089,500.0	0.00%
	2. Ургамалын гаралтай бүтээгдэхүүн	231,598.4	46,407,900.0	0.50%
	3. Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	102,444.3	6,140,600.0	1.67%
	4. Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	0.0	47,216,500.0	0.00%
	Subtotal	334,042.7	101,854,500.0	0.33%
Хэрэглээний бараа бүтээгдэхүүн	7. Хуванцар болон хуванцар эдлэл, каучук болон каучукан эдлэл	12,995.7	13,345,900.0	0.10%
	8. Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	0.0	171,500.0	0.00%
	9. Мод, модон эдлэл	75,342.8	1,720,800.0	4.38%
	10. Целлюлоз цаас, картон	2,302.2	8,744,900.0	0.03%
	11. Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	16,970.6	79,856,200.0	0.02%
	12. Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	56.4	1,802,900.0	0.00%
	14. Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	0.0		
	19. Буу зэвсэг байлдааны хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	0.0		
	20. Аж үйлвэрийн төрөл бүрийн бараа	22,254.9	9,123,800.0	0.24%
	21. Урлагийн бүтээл, цуглуулга хийх зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.0		
	Subtotal	129,922.7	114,766,000.0	0.11%
Эрчим хүчний бүтээгдэхүүн	5. Эрдэс бүтээгдэхүүн	0.0	120,270,400.0	0.00%
	Subtotal	0.0	120,270,400.0	0.00%
Түүхий эд болон эд анги	6. Химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.	108,006.4	28,061,700.0	0.38%
	13. Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	0.0	5,460,300.0	0.00%
	15. Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	149,113.1	22,694,600.0	0.66%
	Subtotal	257,119.6	56,216,600.0	0.46%
Техник тоног төхөөрөмж	16. Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	2,114,692.5	133,302,200.0	1.59%
	18. Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, эдгээрийн эд анги	35,718.4	21,050,300.0	0.17%
	17. Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	29,999.9	67,047,500.0	0.04%
	Subtotal	2,180,410.8	221,400,000.0	0.98%

НИЙТ ИМПОРТ		2,901,495.7	614,507,500.0	0.47%
------------------------	--	--------------------	----------------------	--------------

Хавсралт 2. Монгол улсын еврогоор төлбөр хийсэн импорт, түүний нийт импортод эзлэх жин. 2001 он

		Евро төлбөрт импорт (ам. доллар)	Нийт импорт (ам. доллар)	Евро төлбөрт импорт/ нийт импорт (%)
Хүнсний бүтээгдэхүүн	1. Амьд мал, амьтад, мал малын гаралтай бүтээгдэхүүн	125,467.18	4,938,500.00	2.54%
	2. Ургамалын гаралтай бүтээгдэхүүн	414.51	50,992,100.00	0.00%
	3. Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	0.00	6,764,300.00	0.00%
	4. Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	156,156.85	50,401,800.00	0.31%
	Subtotal	282,038.54	113,096,700.00	0.25%
Хэрэглээний бараа бүтээгдэхүүн	7. Хуванцар болон хуванцар эдлэл, каучук болон каучукан эдлэл	22,359.57	15,108,400.00	0.15%
	8. Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	3,932.94	691,200.00	0.57%
	9. Мод, модон эдлэл	1,071.07	2,155,800.00	0.05%
	10. Целлюлоз цаас, картон	12,070.48	10,347,900.00	0.12%
	11. Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	112,932.44	63,288,100.00	0.18%
	12. Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	157,917.64	2,249,100.00	7.02%
	14. Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	19.51		
	19. Буу зэвсэг байлдааны хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	0.00		
	20. Аж үйлвэрийн төрөл бүрийн бараа	33,381.26		0.38%
	21. Урлагийн бүтээл, цуглуулга хийх зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.00	8,831,600.00	
	Subtotal	343,684.92	102,672,100.00	0.33%
Эрчим хүчний бүтээгдэхүүн	5. Эрдэс бүтээгдэхүүн	1,679.82	143,848,300.00	0.00%
	Subtotal	1,679.82	143,848,300.00	0.00%
Түүхий эд болон эд анги	6. Химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.	429,624.89	33,002,000.00	1.30%
	13. Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	17,528.49	9,756,400.00	0.18%
	15. Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	28,511.19	29,812,100.00	0.10%
	Subtotal	475,664.56	72,570,500.00	0.66%
Техник тоног төхөөрөмж	16. Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	1,330,517.21	112,522,900.00	1.18%
	18. Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, эдгээрийн эд анги	680,512.05	67,884,700.00	1.00%
	17. Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	282,959.95	17,527,200.00	1.61%

	Subtotal	2,293,989.21	197,934,800.00	1.16%
НИЙТ ИМПОРТ		3,397,057.05	630,122,400.00	0.54%

Хавсралт 3. Монгол улсын еврогоор төлбөр хийсэн импорт, түүний нийт импортод эзлэх жин.
2002 он

		Евро төлбөрт импорт (ам. доллар)	Нийт импорт (ам. доллар)	Евро төлбөрт импорт/ нийт импорт (%)
Хүнсний бүтээгдэхүүн	1. Амьд мал, амьтад, мал малын гаралтай бүтээгдэхүүн	282,888.05	5,256,100.00	5.38%
	2. Ургамалын гаралтай бүтээгдэхүүн	100,108.31	58,279,600.00	0.17%
	3. Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	2,872,524.81	9,356,700.00	30.70%
	4. Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	4,233,074.13	56,604,200.00	7.48%
	Subtotal	7,488,595.31	129,496,600.00	5.78%
Хэрэглээний бараа бүтээгдэхүүн	7. Хуванцар болон хуванцар эдлэл, каучук болон каучукан эдлэл	644,783.48	19,058,800.00	3.38%
	8. Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	65,723.04	496,900.00	13.23%
	9. Мод, модон эдлэл	61,685.35	3,237,800.00	1.91%
	10. Целлюлоз цаас, картон	1,127,766.19	14,935,800.00	7.55%
	11. Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	1,156,642.19	84,183,300.00	1.37%
	12. Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	432,166.57	1,918,300.00	22.53%
	14. Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	3,237.65		
	19. Буу зэвсэг байлдааны хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	6,005.13		
	20. Аж үйлвэрийн төрөл бүрийн бараа	603,853.00		6.75%
	21. Урлагийн бүтээл, цуглуулга хийх зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	30.18	9,037,700.00	
	Subtotal	4,101,892.79	132,868,600.00	3.09%
Эрчим хүчний бүтээгдэхүүн	5. Эрдэс бүтээгдэхүүн	28,321.52	132,716,700.00	0.02%
	Subtotal	28,321.52	132,716,700.00	0.02%
Түүхий эд болон эд анги	6. Химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.	2,938,697.89	34,509,400.00	8.52%
	13. Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	185,560.65	10,903,800.00	1.70%
	15. Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	1,001,689.12	31,367,500.00	3.19%
	Subtotal	4,125,947.66	76,780,700.00	5.37%
Техник тоног төхөөрөмж	16. Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	6,988,418.30	134,415,000.00	5.20%
	18. Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, эдгээрийн эд анги	947,943.34	75,511,300.00	1.26%
	17. Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	1,469,709.44	8,956,000.00	16.41%
	Subtotal	9,406,071.07	218,882,300.00	4.30%
НИЙТ ИМПОРТ		25,150,828.36	690,744,900.00	3.64%

Хавсралт 4. Монгол улсын еврогоор төлбөр хийсэн импорт, түүний нийт импортод эзлэх жин. 2003 он

		Евро төлбөрт импорт (ам. доллар)	Нийт импорт (ам. доллар)	Евро төлбөрт импорт/ нийт импорт (%)
Хүнсний бүтээгдэхүүн	1. Амьд мал, амьтад, мал малын гаралтай бүтээгдэхүүн	312,416.17	6,041,800.00	5.17%
	2. Ургамалын гаралтай бүтээгдэхүүн	1,860,240.37	37,917,700.00	4.91%
	3. Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	2,877,622.06	10,293,200.00	27.96%
	4. Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	4,611,571.56	61,320,000.00	7.52%
	Subtotal	9,661,850.16	115,572,700.00	8.36%
Хэрэглээний бараа бүтээгдэхүүн	7. Хуванцар болон хуванцар эдлэл, каучук болон каучукан эдлэл	1,225,880.92	22,037,500.00	5.56%
	8. Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	102,940.39	451,100.00	22.82%
	9. Мод, модон эдлэл	151,566.88	4,423,000.00	3.43%
	10. Целлюлоз цаас, картон	4,358,755.10	25,527,800.00	17.07%
	11. Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	1,339,630.91	83,539,300.00	1.60%
	12. Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	540,647.69	1,653,500.00	32.70%
	14. Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	28,576.69	127,400.00	22.43%
	19. Буу зэвсэг байлдааны хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	70,446.60	333,800.00	21.10%
	20. Аж үйлвэрийн төрөл бүрийн бараа	1,233,151.78	12,050,700.00	10.23%
	21. Урлагийн бүтээл, цуглуулга хийх зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	2,163.51	21,900.00	9.88%
	Subtotal	9,053,760.47	150,166,000.00	6.03%
Эрчим хүчний бүтээгдэхүүн	5. Эрдэс бүтээгдэхүүн	103,550.44	166,510,100.00	0.06%
	Subtotal	103,550.44	166,510,100.00	0.06%
Түүхий эд болон эд анги	6. Химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.	5,677,227.26	43,016,900.00	13.20%
	13. Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	630,102.05	17,013,100.00	3.70%
	15. Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	2,889,261.58	43,802,100.00	6.60%
	Subtotal	9,196,590.89	103,832,100.00	8.86%
Техник тоног төхөөрөмж	16. Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	29,596,989.57	167,977,700.00	17.62%
	18. Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, эдгээрийн эд анги	1,796,610.00	87,070,500.00	2.06%
	17. Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	2,150,511.86	9,890,600.00	21.74%
	Subtotal	33,544,111.43	264,938,800.00	12.66%
НИЙТ ИМПОРТ		61,559,863.40	801,019,700.00	7.69%

Хавсралт 5. Монгол улсын еврогоор төлбөр хийсэн импорт, түүний нийт импортод эзлэх жин. 2004 оны 9 сар

		Евро төлбөрт импорт (ам. доллар)	Нийт импорт (ам. доллар)	Евро төлбөрт импорт/ нийт импорт (%)
Хүнсний бүтээгдэхүүн	1. Амьд мал, амьтад, мал малын гаралтай бүтээгдэхүүн	260,487.16	4,522,500.00	5.76%
	2. Ургамалын гаралтай бүтээгдэхүүн	1,547,300.57	50,154,800.00	3.09%
	3. Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	1,080,106.56	6,922,100.00	15.60%
	4. Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	3,747,492.19	50,650,900.00	7.40%
	Subtotal	6,635,386.47	112,250,300.00	5.91%
Хэрэглээний бараа бүтээгдэхүүн	7. Хуванцар болон хуванцар эдлэл, каучук болон каучукан эдлэл	960,126.16	19,044,900.00	5.04%
	8. Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	384,479.77	2,813,700.00	13.66%
	9. Мод, модон эдлэл	6,633,539.00	14,230,400.00	46.62%
	10. Целлюлоз цаас, картон	1,063,264.37	84,502,300.00	1.26%
	11. Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	161,164.63	1,042,400.00	15.46%
	12. Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	58,033.72	426,500.00	13.61%
	14. Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	20,118.97	54,200.00	37.12%
	19. Буу зэвсэг байлдааны хэрэгсэл, тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл	38,797.21	332,000.00	11.69%
	20. Аж үйлвэрийн төрөл бүрийн бараа	583,065.02	8,690,300.00	6.71%
	21. Урлагийн бүтээл, цуглуулга хийх зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	4,573.46	24,600.00	18.59%
	Subtotal	9,907,162.31	131,161,300.00	7.55%
	Эрчим хүчний бүтээгдэхүүн	5. Эрдэс бүтээгдэхүүн	60,776.38	154,865,200.00
Subtotal		60,776.38	154,865,200.00	0.04%
Түүхий эд болон эд анги	6. Химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн.	3,434,978.97	33,292,800.00	10.32%
	13. Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	320,815.46	12,685,700.00	2.53%
	15. Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	1,489,387.27	54,357,500.00	2.74%
	Subtotal	5,245,181.70	100,336,000.00	5.23%
Техник тоног төхөөрөмж	16. Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	22,988,432.08	160,648,200.00	14.31%
	18. Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, эдгээрийн эд анги	1,987,764.00	80,018,100.00	2.48%
	17. Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	1,335,443.54	13,305,200.00	10.04%
	Subtotal	26,311,639.62	253,971,500.00	10.36%
НИЙТ ИМПОРТ		48,160,146.46	752,584,300.00	6.40%